

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/019/НА-СТА-ТХН

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn | Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn |
| Улаанбаатар хот 2025 он | Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 51-2608512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn |
| | Аудитор: Д.Номингуа Утас: 51-261628 Цахим хаяг: nominguad@audit.gov.mn |
| | Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Утас: 976-91910954 Цахим хаяг: dabg.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/674
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөний дагуу сонгон шалгаруулалт хийгдсэн 1,645,512.5 мянган төгрөгийн 1 ажил, 2,026,512.0 мянган төгрөгийн 14 зөвлөх үйлчилгээг Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 01/10803 дугаар албан бичгээр ирүүлсэн зарим ажил, үйлчилгээний санхүүжилтийг түр хойшлуулах жагсаалтад орсон тул гэрээ байгуулахыг хойшлуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2024 оны 04 дүгээр тогтоолоор “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/65 дугаар тушаалаар хөтөлбөр хэрэгжүүлэх удирдамжийг баталсан. ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/63 дугаар тушаалаар банк сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдан ажиллаж, ХААН болон Төрийн банкууд шалгарсан байна.

Сонгогдсон банкуудтай 2024 оны 6 дугаар сарын 08-ны өдөр гэрээ байгуулж 13,000,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг байршуулснаар бичил бизнесийн зээл олголт 68.4 хувьтай хэрэгжсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 7,073,169,359.99 | 3,217,544,737.40 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 7,059,083,178.36 | 3,208,632,555.77 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 7,059,083,178.36 | 3,208,632,555.77 |
| 3121 | Төгрөг | 1,886,264,862.51 | 1,928,840,708.78 |
| 31210 | Төрийн сангийн харилцах | 1,886,264,862.51 | 1,928,840,708.78 |
| 3122 | Гадаад валют | 5,172,818,315.85 | 1,279,791,846.99 |
| 31221 | Төрийн сангийн харилцах | 5,172,818,315.85 | 1,279,791,846.99 |
| 33 | Авлага | 5,472,000.00 | 5,496,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 24,000.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 5,472,000.00 | 5,472,000.00 |
| 34 | Урьдчилгаа | 2,000,000.00 | - |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 2,000,000.00 | - |
| 35 | Бараа материал | 6,614,181.63 | 3,416,181.63 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,614,181.63 | 3,416,181.63 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 127,768,167.15 | 148,451,131.90 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 127,768,167.15 | 148,451,131.90 |
| 392 | Биет хөрөнгө | 120,078,666.95 | 142,451,631.70 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 131,727,272.73 | 131,727,272.73 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (71,352,272.56) | (84,524,999.83) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 87,500,454.55 | 140,783,090.55 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (47,307,337.78) | (60,759,999.86) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 42,842,819.00 | 42,842,819.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (23,332,268.99) | (27,616,550.89) |
| 393 | Биет бус хөрөнгө | 7,689,500.20 | 5,999,500.20 |
| 39301 | Програм хангамж | 16,900,000.00 | 16,900,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (9,210,499.80) | (10,900,499.80) |
| 2 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 7,200,937,527.14 | 3,365,995,869.30 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 6,916,790.70 | 24,000.00 |
| 413 | Богино хугацаат өр төлбөр | 6,916,790.70 | 24,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 6,916,790.70 | 24,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 7,194,020,736.44 | 3,365,971,869.30 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 7,194,020,736.44 | 3,365,971,869.30 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,527,409,183.16 | 7,194,020,736.44 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 4,666,611,553.28 | (3,828,048,867.14) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 7,200,937,527.14 | 3,365,995,869.30 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|---|-------------------------|----------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 5,318,740,221.99 | 14,529,259,000.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,318,740,221.99 | 14,529,259,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5,318,740,221.99 | 14,529,259,000.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 5,163,075,000.00 | 14,528,809,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Хөрөнгө | 155,665,221.99 | - |
| 120009 | Бусад орлого | - | 450,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 638,536,202.77 | 5,335,675,134.68 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 638,536,202.77 | 5,335,675,134.68 |
| 210 | Бараа, ажил үйлчилгээний зардал | 638,536,202.77 | 5,335,675,134.68 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 306,018,459.13 | 428,574,614.21 |
| 210101 | Үндсэн цалин | 306,018,459.13 | 428,574,614.21 |
| 2102 | АО-с нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 37,859,738.10 | 52,378,436.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,859,738.10 | 52,378,436.01 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 68,220,000.00 | 74,090,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 68,220,000.00 | 74,090,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,303,266.08 | 11,262,724.22 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,925,509.94 | 2,082,380.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 863,636.36 | 1,300,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,514,119.78 | 7,408,763.22 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 471,581.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 980,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | 980,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний | 189,237,684.62 | 2,182,208,971.55 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээ | 189,237,684.62 | 2,180,493,141.55 |
| 210803 | Тээврийн хэрэгслийн даатгал | - | 1,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 215,830.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,897,054.84 | 32,599,671.25 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 27,897,054.84 | 32,599,671.25 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 2,553,580,717.44 |
| 221002 | Тоног төхөөрөмж | - | 2,553,580,717.44 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | 4,680,204,019.22 | 9,193,583,865.32 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО | 50,350,806.99 | 31,868,022.31 |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз | 50,350,806.99 | 31,868,022.31 |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 63,943,272.93 | 13,053,500,754.77 |
| 225001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз | 63,943,272.93 | 53,500,754.77 |
| 225009 | Дамжуулан зээлдүүлэх зээл | - | 13,000,000,000.00 |
| 6 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН | (13,592,465.94) | (13,021,632,732.46) |
| 7 | НИЙТ ҮР ДҮН | 4,666,611,553.28 | (3,828,048,867.14) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|------------|--|-------------------------|----------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 5,163,075,000.00 | 14,529,259,000.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,163,075,000.00 | 14,529,259,000.00 |
| 120 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 5,163,075,000.00 | 14,529,259,000.00 |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 5,163,075,000.00 | 14,528,809,000.00 |
| 120009 | Бусад орлого | - | 450,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 618,934,538.86 | 2,804,496,172.69 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 618,934,538.86 | 2,804,496,172.69 |
| 210 | Бараа, ажил үйлчилгээний зардал | 618,934,538.86 | 2,804,496,172.69 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 279,293,886.07 | 428,574,614.21 |
| 210101 | Үндсэн цалин | 279,293,886.07 | 428,574,614.21 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 37,859,738.10 | 52,378,436.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,859,738.10 | 52,378,436.01 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 68,220,000.00 | 74,090,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 68,220,000.00 | 74,090,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,303,266.08 | 11,262,724.22 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,925,509.94 | 2,082,380.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 863,636.36 | 1,300,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,514,119.78 | 7,408,763.22 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 471,581.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 980,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | 980,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал | 224,257,648.61 | 2,237,210,398.25 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 224,257,648.61 | 2,235,494,568.25 |
| 210803 | Тээврийн хэрэгслийн даатгал | - | 1,500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | - | 215,830.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 4,544,140,461.14 | 11,724,762,827.31 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 2,553,580,717.44 |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН | - | 2,553,580,717.44 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | (2,553,580,717.44) |
| 6 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз | 50,350,806.99 | 31,868,022.31 |
| 225004 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз | 63,943,272.93 | 53,500,754.77 |
| 225009 | Дамжуулан зээлдүүлэх зээл | - | 13,000,000,000.00 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (13,592,465.94) | (13,021,632,732.46) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 4,530,547,995.2 | (3,850,450,622.59) |

| | | | |
|----|--|-------------------------|-------------------------|
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 2,528,535,183.16 | 7,059,083,178.36 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 7,059,083,178.36 | 3,208,632,555.77 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-------------------------|--|
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | 2,527,409,183.16 | 2,527,409,183.16 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | 2,527,409,183.16 | 2,527,409,183.16 |
| Тайлант үеийн үр дүн | | 4,666,611,553.28 | 4,666,611,553.28 |
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | 7,194,020,736.44 | 7,194,020,736.44 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | 2,527,409,183.16 | 2,527,409,183.16 |
| Тайлант үеийн үр дүн | | (3,828,048,867.14) | (3,828,048,867.14) |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | 3,365,971,869.30 | 3,365,971,869.30 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-----------------------|--|--------------------------|--------------------------|-------------------------|-------|
| 2 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 22,000,000,000.00 | 18,358,076,890.13 | 3,641,894,690.87 | 83.4 |
| 21 | Урсгал зардал | 5,000,000,000.00 | 2,804,496,172.69 | 2,195,475,408.31 | 56.1 |
| 210 | Бараа, ажил үйлчилгээний зардал | 5,000,000,000.00 | 2,804,496,172.69 | 2,195,475,408.31 | 56.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 456,000,000.00 | 428,574,614.21 | 27,425,385.79 | 94.0 |
| 210101 | Үндсэн цалин | 456,000,000.00 | 428,574,614.21 | 27,425,385.79 | 94.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 84,000,000.00 | 52,378,436.01 | 31,621,563.99 | 62.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 84,000,000.00 | 52,378,436.01 | 31,621,563.99 | 62.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 78,000,000.00 | 74,090,000.00 | 3,910,000.00 | 95.0 |
| 210304 | Байрны түрээс | 78,000,000.00 | 74,090,000.00 | 3,910,000.00 | 95.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 28,900,000.00 | 11,262,724.22 | 17,608,856.78 | 39.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,500,000.00 | 2,082,380.00 | 2,417,620.00 | 46.3 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,400,000.00 | 1,300,000.00 | 4,100,000.00 | 24.1 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 18,500,000.00 | 7,408,763.22 | 11,091,236.78 | 40.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 | 471,581.00 | 28,419.00 | 94.3 |
| 2107 | Томиллот, зочны зардал | 1,000,000.00 | 980,000.00 | 20,000.00 | 98.0 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 1,000,000.00 | 980,000.00 | 20,000.00 | 98.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,352,100,000.00 | 2,237,210,398.25 | 2,114,889,601.75 | 51.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,352,100,000.00 | 2,237,210,398.25 | 2,114,889,601.75 | 51.4 |
| 22 | Хөрөнгийн зардал | 4,000,000,000.00 | 2,553,580,717.44 | 1,446,419,282.56 | 63.8 |
| 221001 | Их засвар | 1,000,000,000.00 | - | 1,000,000,000.00 | - |
| 222001 | Тоног төхөөрөмж | 3,000,000,000.00 | 2,553,580,717.44 | 446,419,282.56 | 85.1 |
| 23 | Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | 13,000,000,000.00 | 13,000,000,000.00 | - | 100.0 |
| 232001 | Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 13,000,000,000.00 | 13,000,000,000.00 | - | 100.0 |
| 1 | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 22,000,000,000.00 | 14,528,809,000.00 | 7,471,191,000.00 | 66.0 |
| 120 | Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас | 22,000,000,000.00 | 14,528,809,000.00 | 7,471,191,000.00 | 66.0 |
| 120044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 22,000,000,000.00 | 14,528,809,000.00 | 7,471,191,000.00 | 66.0 |
| 3 | Тохируулсан орлогын дүн | | (21,182,732.46) | | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 7,059,083,178.36 | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 3,208,632,555.77 | | |
| 6 | Төсвийн бусад мэдээллийн ангилал | | | | |
| 61 | Байгууллагын тоо | 1 | 1 | - | |
| 62 | Ажиллагсадын тоо | 8 | 8 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 7 | 7 | - | 100.0 |

3. АУДИТЫН ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ:

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.1.Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн байршуулаагүй 5,858.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: | | | |
|---|-------------|--------------------|-----------------|--------------------|----------|----------|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | |
| Төслийн нэгж нь нэгж нь шилэн дансны цахим хуудсанд байршуулах ёстой нийт 159 мэдээнээс 5,858,003.2 мянган төгрөгийн худалдан авалттай холбоотой нэг мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна . | 1 | 5,858,003.2 | 1 | 5,858,003.2 | | |
| Дүн | 1 | 5,858,003.2 | 1 | 5,858,003.2 | - | - |